



**БИДИСЕК ҮЦК ХК**  
Андеррайтер, Брокер, Хөронго оруулалтын зөвлөх



**БИДИСЕК ҮЦК ХК-ИЙН 2017 ОНЫ  
ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ТАЙЛАН**

## **АГУУЛГА**

<b>Тайлангийн эхний хэсэг .....</b>	<b>3</b>
Үнэт цаас гаргагчийн нэр, оршин суугаа хаяг:.....	3
Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэл: .....	3
Үнэт цаас гаргагчийн зорилго, үйл ажиллагааны стратеги, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл: .....	3
Үнэт цаас гаргагчийн түүх, тухайн зах зээлд эзэлж буй байр суурь, судалгаа: .....	3
Үнэт цаас гаргагчийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд гаргасан томоохон өөрчлөлт, үүнтэй холбоотой үүсч болох эрсдлийн тухай мэдээлэл: .....	3
1. Брокерийн үйл ажиллагаа:.....	4
2. Андеррайтерийн үйлчилгээ: .....	4
3. Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ: .....	4
4. Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдаж авахад зуучлах үйлчилгээ:.....	5
Үнэт цаас гаргагчийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч этгээдийн талаарх мэдээлэл: 5	5
Үнэт цаас гаргагчийн удирдлага, эрх бүхий албан тушаалтны танилцуулга:.....	5
Үнэт цаас гаргагчийн нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшигчдийн мэдээлэл:.....	6
<b>Тайлангийн хоёрдахь хэсэг .....</b>	<b>6</b>
Санхүүгийн тайлангийн үзүүлэлт: .....	6
Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүд .....	11
Брокерийн үйл ажиллагаа.....	12
Харилцагч.....	13
Андеррайтерийн үйл ажиллагаа .....	13
Санхүүгийн тайлан .....	14
Хараат бус аудиторын тайлан.....	17
<b>Тайлангийн гуравдахь хэсэг.....</b>	<b>24</b>

## **ТАЙЛАНГИЙН ЭХНИЙ ХЭСЭГ**

Үнэт цаас гаргагчийн нэр, оршин суугаа хаяг:

“БиДиСЕК ҮЦК” Хувьцаат Компани

Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Залуучуудын өргөн чөлөө-27/1, Сүхбаатар дүүрэг,  
8-р хороо

Утас: 11-321763

Факс: 11-321763

Электрон хаяг: www.bdsec.mn

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэл:

Улсын бүртгэлийн дугаар: 9010001030

Регистрын дугаар: 2052482

Үйл ажиллагааны чиглэл: Брокер дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх  
Хувьцаа эзэмшигчдийн тоо: 474 /2017 оны 12-р сарын 31-ний өдрөөр/

Үнэт цаас гаргагчийн зорилго, үйл ажиллагааны стратеги, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл:

Эрхэм зорилго: Үндэсний үйлдвэрлэлийг хөрөнгө оруулалт, санхүүгийн цогц үйлчилгээгээр дэмжих, олон улсын стандартанд нийцсэн санхүүгийн зах зээлд тэргүүлэгч байгууллага болох.

Үнэт цаас гаргагчийн түүх, тухайн зах зээлд эзэлж буй байр суурь, судалгаа:

“БиДиСЕК ҮЦК” ХК-ийн үйл ажиллагаа Монгол Улсад Хөрөнгийн Зах Зээл үүссэн 1991 оноос эхэлсэн бөгөөд өдгөө 26 дахь жилдээ үйл ажиллагаагаа явуулж буй тус салбарын ууган компаниудын нэг юм.

БиДиСЕК ҮЦК нь Монголын Хөрөнгийн зах зээл дээр Андеррайтер, Брокер, Дилер, Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээг гадаад дотоодын харилцагчид, түнш байгууллагууддаа цогцоор нь чанарын өндөр түвшинд үзүүлж, урт хугацааны итгэлтэй түншлэлийн харилцааг эрхэмлэн ажиллаж ирсэний үр дүнд дотоодын Хөрөнгийн зах зээлийн тэргүүлэгч компани болж чадсан.

Энэ бүхнийг манай компанийн үйлчилж буй харилцагчидын тоо, үнэт цаасны арилжааны хэмжээ, гаргасан IPO, санхүүгийн чадвар, тогтвортой байдал, харилцагчиддаа үзүүлдэг үйлчилгээний төрөл зэрэг олон үзүүлэлтүүд илтгэдэг.

2017 оны жилийн эцсийн байдлаар үнэт цаасны зах зээлд оролцох данстай харилцагчдын тоо, нийт зах зээлийн харилцагчдын 25 хувь буюу 200,000 гаруй харилцагчдтай болсон.

Үнэт цаас гаргагчийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлд гаргасан томоохон өөрчлөлт, үүнтэй холбоотой үүсч болох эрсдлийн тухай мэдээлэл:

“БиДиСЕК ҮЦК” ХК-ийн үндсэн бизнес нь Монголын хөрөнгийн зах зээл дээрээс гадаад дотоодын хөрөнгө оруулагчид үнэт цаас худалдан авахад зуучлал /брокер/, аж

ахуй нэгжүүдэд үнэт цаас гарган хөрөнгө оруулалт татах андеррайтерийн үйл ажиллагаа юм.

Мөн биржид компаниуд шинээр бүртгүүлэх, бүртгэлтэй хувьцаат компаниудын засаглалыг сайжруулах, үр ашиг бүхий төсөлд хөрөнгө оруулалт татах, иргэдэд үнэт цаасны арилжаанд оролцоход Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээг үзүүлдэг.

Эдгээр үйлчилгээнүүдийн манай компанийн салбартаа олон жил ажилласан туршлагатай, чадварлаг удирдлага, зөвлөх мэргэжилтнүүд Монгол Улсын хууль тогтоомж, зохицуулах байгууллагуудын дүрэм журамд нийцүүлэн чанарын өндөр түвшинд үзүүлж байна.

1. Брокерийн үйл ажиллагаа: “БидиСЕК ҮЦК” ХК нь харилцагч, хөрөнгө оруулагчдад Монголын Хөрөнгийн зах зээл дээрээс үнэт цаас худалдан авах, худалдах захиалгыг зуучлалын үйл ажиллагаа буюу брокерийн үйлчилгээг дамжуулан түргэн шуурхай гүйцэтгэж байна.

- a) Төл И брокер
- b) Арилжааны танхим
- c) Сургалт зөвлөгөө
- d) Мэдээлэл, судалгаа
- e) Хөрөнгө оруулагчдын уулзалт
- f) Багцын арилжаа
- g) Бусад нэмэлт үйлчилгээнүүд

2. Андеррайтерийн үйлчилгээ: Бид андеррайтерийн үйл ажиллагааны хүрээнд санхүүжилт шаардлагатай байгаа компанийн үнэт цаасыг хаалттай болон нээлттэй хүрээнд хөрөнгө оруулагчидад зуучлан борлуулах, зарим тохиолдолд үнэт цаасыг нь анхдагч зах зээл дээрээс бүхлээр нь болон хэсэгчлэн худалдан авах, үнэт цаасны бүртгэлийн болон анхдагч зах зээлийн арилжааг удирдан зохион байгуулан ажилладаг.

- a) Хувьцаагаар санхүүжилт татах
  - 1) Шууд хөрөнгө оруулалт
  - 2) Шинээр хувьцаа гаргах буюу IPO
  - 3) Давуу эрхийн хувьцаа
  - 4) Нэмэлт хувьцаа гаргах буюу FPO
- b) Зээлийн санхүүжилт
  - 1) Хаалттай бонд
  - 2) Нээлттэй бонд
  - 3) Хөрвөх зээл
  - 4) Хөрвөх бонд

3. Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ: Манай компани 2007 онд “Санхүүгийн Зохицуулах Хороо”-ноос Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх эрхийг авсанаар үнэт цаасанд хөрөнгө оруулах сонирхолтой хувь хүн, аж ахуйн нэгж байгууллагад хөрөнгө оруулалт хийхэд нь зөвлөх, санхүүжилт шаардлагатай байгаа компаниудад хөрөнгийн зах зээл дээрээс санхүүжилт татах боломжийн талаар зөвлөгөө өгөн ажиллаж байна

- a) Иргэдэд зориулсан цогц үйлчилгээ
- b) Аж ахуйн нэгжүүдэд зориулсан үйлчилгээ
  - i. Тендер санал зарлах
  - ii. Компанийн хэлбэрийг өөрчлөх
  - iii. Хувьцаа эзэмшигчдийн хурал
  - iv. Санхүүжилт татах
  - v. Компанийн засаглалын зөвлөгөө зэрэг үйлчилгээнүүдийг харилцагч байгууллагуудад хүргэж байна.

4. Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдаж авахад зуучлах үйлчилгээ: Манай компани 2017 оны 3-р сарын 22-ний өдөр Санхүүгийн Зохицуулах Хорооноос уг зөвшөөрлийг авч, харилцагч, хөрөнгө оруулагчдад гадаадын томоохон хөрөнгийн зах зээл дээрээс үнэт цаас худалдан авах, худалдах захиалгыг зуучлалын үйл ажиллагааг гүйцэтгэж байна

Үнэт цаас гаргагчийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч этгээдийн талаарх мэдээлэл:

- Компанийн хяналтын багц эзэмшигчдийн мэдээлэл:

№	Овог нэр	Албан тушаал	Хувьцааны хувь
1	Д.Даянбилгүүн	Гүйцэтгэх захирал	19.06%
2	Б.Лхагвадорж	Тэргүүн дэд захирал	3.68%
3	Н.Батгэрэл	Дэд захирал	2.57%
4	Firebird MF Holdings S.A.R.L	-	6.50%
5	Firebird Global Master Fund Holdings-1 S.A.R.L	-	5.23%
6	Firebird GM 2 S.A.R.L	-	7.70%
7	Impera Mongolia Holdings Ltd	-	5.44%
8	Германы Хөрөнгө Оруулагч	-	23.14%

Үнэт цаас гаргагчийн удирдлага, эрх бүхий албан тушаалтны танилцуулга:

№	Овог нэр	Албан тушаал	Боловсрол
1	Д.Даянбилгүүн	Гүйцэтгэх захирал	Дээд
2	Б.Лхагвадорж	Тэргүүн дэд захирал	Дээд
3	Н.Батгэрэл	Дэд захирал	Дээд
4	James Passin	ТУЗ-ийн гишүүн	Дээд
5	Д.Амгаланбаяр	ТУЗ-ийн гишүүн	Дээд
6	Hitoshi Tani	ТУЗ-ийн гишүүн	Дээд
7	Б.Энхбаяр	ТУЗ-ийн гишүүн	Дээд
8	Б.Амарсанаа	ТУЗ-ийн гишүүн	Дээд
9	Philip Khoury	ТУЗ-ийн гишүүн	Дээд
10	Ө.Даваасүрэн	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	Дээд
11	С.Пүрэвсүрэн	Дотоод албаны менежер	Дээд
12	Г.Гэрэлт-Од	Ерөнхий нягтлан бодогч	Дээд
13	Ш.Шинэбаяр	Хөрөнгө оруулалтын албаны менежер	Дээд
14	О.Уранбайгаль	Back Office албаны менежер	Дээд

Үнэт цаас гаргагчийн нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшигчдийн мэдээлэл:

/2017.12.31-ний байдлаар/

№	Овог нэр	Албан тушаал	Хувьцааны хувь
1	Д.Даянбилгүүн	Гүйцэтгэх захирал	19.06%
2	АНУ-н хөрөнгө оруулалтын сан	-	19.43%
3	Impera Mongolia Holdings Ltd	-	5.44%
4	ХБНГУ-н хөрөнгө оруулагч	-	23.14%

## ТАЙЛАНГИЙН ХОЁРДАХЬ ХЭСЭГ

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ:

1. Компанийн 2015, 2016, 2017 оны орлогын тайлангийн үзүүлэлтээс зэрэгцүүлэн үзвэл:

Үзүүлэлт /мян.төг/	2015 он*	2016 он*	2017 он*
Борлуулалт	797,159	879,635	2,106,342.7
Борлуулалтын хөнгөлөлт	-	-	-
Цэвэр борлуулалт	797,159	879,635	2,106,342.7
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	-	-
Үйл ажиллагааны зардал	(1,316,319)	(1,501,327)	(1,769,354.4)
<b>Үйл ажиллагааны ашиг /алдагдал/</b>	<b>(397,675)</b>	<b>(500,476)</b>	<b>473,390.8</b>
Санхүүгийн орлого	515,541.0	529,962.9	758,591.5
Санхүүгийн зардал	(98,323.0)	(756,959.5)	(177,927.5)
Өмчөөр тайлагнагдах хараат компанийн цэвэр ашгийн ногдох хувь	32015.0	107,930.5	141,898.8
Үйл ажиллагааны бус зардал	(25,088)	(85,915)	(17,445.3)
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг /алдагдал/</b>	<b>26,470</b>	<b>(705,448)</b>	<b>1,178,508.3</b>
Орлогын татварын зардал	(6,945)	(5,065)	(80,154.7)
<b>Цэвэр ашиг /алдагдал/</b>	<b>19,526</b>	<b>(710,514)</b>	<b>1,098,353.5</b>

\*Үнэт цаасны зах зээл дээр брокер, дилер, андеррайтерийн үйл ажиллагаа явуулах этгээдэд мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн үлгэрчилсэн загварын дагуу Компанийн 2015, 2016, 2017 оны хөрөнгө, эх үүсвэрийн тэнцлийн үзүүлэлтээс зэрэгцүүлэн үзвэл:

Хөрөнгө, өр төлбөрийн үзүүлэлтүүд /мянган төгрөгөөр/	2015 он	2016 он	2017 он
Эргэлтийн хөрөнгө	9,218,669	9,168,401	13,487,930
Эргэлтийн бус хөрөнгө	6,497,853	5,556,013	5,408,168
Нийт хөрөнгийн дүн	14,727,657	14,724,414	18,896,098
Богино хугацаат өр төлбөр	441,528	138,200	3,211,530.9
Урт хугацааны өр төлбөр	-	-	-

2. Компани нь 2017 оны жилийн эцсийн байдлаар 1,098 сая төгрөгийн цэвэр ашигтай байна. Мөн өөрийн хөрөнгийн хэмжээ нь 15.68 тэрбум төгрөг, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 9.32 тэрбум төгрөг байна.

3. Үнэт цаас гаргагчийн удирдлага, эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ, тэдгээр нь үнэт цаас эзэмшдэг талаарх мэдээлэл /2017.12.31-ний байдлаар/:

№	Овог, Нэр	Цалин урамшуулалын хэмжээ /жил/	Хандив тусламж	Бусад	Эзэмшиж буй хувьцааны тоо
1	Б.Лхагвадорж	6,000,000	-	-	3,68%
2	Д.Даянбилгүүн	6,000,000	-	-	19.06%
3	Н.Батгэрэл	6,000,000	-	-	2.57%
4	James Passin	6,000,000	-	-	-
5	Амгаланбаяр	6,000,000	-	-	2.43%
6	Hitoshi Tani	6,000,000	-	-	2.26%
7	Б.Энхбаяр	6,000,000	-	-	0.001%
8	Б.Амарсанаа	6,000,000	-	-	-
9	Philip Khoury	6,000,000	-	-	-

4. Ногдол ашгийн талаарх мэдээлэл:

“БиДиСЕК ҮЦК” ХК нь 2006 оноос хойш нийтдээ 6 удаа хувьцаа эзэмшигч нартаа ногдол ашиг тараасан ба 2013 онд нэгж хувьцаанд 11.78 төгрөг, 2012 онд нэгж хувьцаанд 60 төгрөг, 2010 онд нэгж хувьцаанд 50 төгрөг, 2008 онд нэгж хувьцаанд 5 төгрөг, 2007 онд нэгж хувьцаанд 30 төгрөг, 2006 онд нэгж хувьцаанд 3 төгрөгийг тус тус тараасан болно.

5. Компанийн тухай хуулийн 87, 89 дүгээр зүйлд заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийсэн эсэх талаарх мэдээлэл:

“БиДиСЕК ҮЦК” ХК нь 2017 онд “Компанийн тухай хууль”-ийн 87 зүйлд заасан их хэмжээний хэлцэл хийгээгүй болно. Мөн “Компанийн тухай хууль”-ийн 89 дүгээр зүйлд заасан сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгээгүй болно.

6. Үнэт цаас гаргагчийн ТУЗ, дэд хороодын үйл ажиллагааны тайлан:

Овог нэр	Эрхэлдэг ажил	Эзэмшсэн боловсрол мэргэжил	Эзэмшиж байгаа хувьцааны тоо, хувь	Хараат бус гишүүн эсэх
1.Б.Лхагвадорж	ТУЗ-ийн дарга	Дээд, нефтьийн инженер	3.68%	Хараат
2.Д.Даянбилгүүн	ТУЗ-ийн гишүүн	Дээд, Бизнесийн удирдлага	19.06%	Хараат
3.Н.Батгэрэл	ТУЗ-ийн гишүүн	Дээд, Гадаад харилцаа	2.57%	Хараат
4.James Passin	ТУЗ-ийн гишүүн	Дээд	-	Хараат
5.Philip Khoury	ТУЗ-ийн гишүүн	Дээд	-	Хараат
6.Д.Амгаланбаяр	ТУЗ-ийн гишүүн	Дээд	2.43%	Хараат бус
7.Hitoshi Tani	ТУЗ-ийн гишүүн	Дээд	2.26%	Хараат бус
8.Б.Энхбаяр	ТУЗ-ийн гишүүн	Дээд	0.001%	Хараат бус
9.Б.Амарсанаа	ТУЗ-ийн гишүүн	Дээд	-	Хараат бус

Компани нь 2017 оны 04-р сарын 26-ны өдөр “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-ыг зарлан хуралдуулж, ТУЗ-ын гишүүдийг дахин сонгосон бөгөөд 2017 оны 05-р сарын 05-ний өдөр ТУЗ-ийн хурлыг хуралдуулан, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргаар Б.Лхагвадоржийг томилж, ТУЗ-ийн дэргэдэх дэд хороодыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсон.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх аудитын хороог Хитоши Тани, Жэймс Пассин, Д.Амгаланбаяр гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Аудитын хорооны даргаар ТУЗ-ийн хараат бүс гишүүн Хитоши Тани-г томилсон.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Цалин урамшуулалын хороог Н.Батгэрэл, Б.Амарсанаа, Д.Амгаланбаяр гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Цалин урамшууллын хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Н.Батгэрэл-г томилсон.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороог Д.Даянбилгүүн, Б.Энхбаяр, Филип Кури гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Нэр дэвшүүлэх хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Д.Даянбилгүүн-г томилсон.

2017 онд Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг гарган баталж, 7 удаа ирц бүрдүүлэн хуралдаж ХЭХ-аас гаргасан тогтоол шийдвэрийн дагуу 11 асуудал хэлэлцэж нийт хэлэлцсэн асуудлаар 11 тогтоол баталж, гүйцэтгэлд хяналт тавьж дүгнэж ажилласан



## ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

### ТОВЧ ТАНИЛЦУУЛГА


БидиСЕК ҮЦК хувьцаат компанийн үйл ажиллагаа Монгол Улсад Хөрөнгийн Зах Зээл үүссэн 1991 онд эхэлсэн бөгөөд өнөөг хүртэл нийт 200 гаруй мянган харилцагчидтай болсон.

Бид Монголын Хөрөнгийн Зах Зээл дээр Андеррайтер, Брокер, Дилер, Хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээг гадаад дотоодын харилцагчид, түнш байгууллагууддаа цогцоор нь чанарын өндөр түвшинд үзүүлж урт хугацааны итгэлтэй түншлэлийн харилцааг эрхэмлэн ажиллаж ирсний үр дүнд дотоодын хөрөнгийн зах зээлийн тэргүүлэгч компани болж чадсан.

Мөн Монгол Улсын эдийн засаг, салбаруудын хөгжил дэвшилд багагүй хувь нэмэр оруулсаар ирсэн ба Андеррайтерийн үйлчилгээгээрээ дамжуулан металлургын салбарт анхны төмрийн үйлдвэр, аялал жуулчлалын салбарт томоохон цогцолбор, нүүрс боловсруулах салбарт хагас коксын үйлдвэр, хаягдал тос боловсруулах үйлдвэр, уул уурхайн салбарт нүүрсний уурхай, мал аж ахуйн салбарт боловсруулах үйлдвэрийн санхүүжилт, дэд бүтэц, тээврийн салбарт ачаа шилжүүлэн ачих терминалын санхүүжилт зэрэг олон чухал төслийн хөрөнгө оруулалтыг хөрөнгийн зах зээлээс босгосон.

2008 оноос эхлэн ТУЗ-ийн гишүүнээр АНУ, Их Британ, Япон улсын олон улсад нэр хүндтэй томоохон компаниудын удирдлага, хөрөнгө оруулагчдын төлөөлөгчид сонгогдсон бөгөөд энэ онд нийт 4 хараат бус гишүүнтэйгээр компанийн засаглалын зохистой харьцааг хэрэгжүүлэн ажиллаж байна.

### БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



## ЭРХЭМ ЗОРИЛГО:

Үндэсний үйлдвэрлэлийг хөрөнгө оруулалт, санхүүгийн цогц үйлчилгээгээр дэмжих, олон улсын стандартанд нийцсэн, санхүүгийн зах зээлд тэргүүлэгч байгууллага болох.

### Урт хугацаанд:

Олон улсын стандартад нийцсэн үйл ажиллагаа явуулах, Үндэсний томоохон хувьцаат компаниудыг шинээр бий болгох

### Дунд хугацаанд:

Үндэсний томоохон үйлдвэрлэгчдийг дэмжих, Олон улсын хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулах, МХЗЗ-д оролцогчдын хүрээг нэмэгдүүлэх

### Богино хугацаанд:

Гадаад харилцааг өргөжүүлэх, Үнэт цаасны арилжааг идэвхжүүлэх, Компанийн боловсон хүчнийг чадваржуулах, Харилцагчдыг ХХЗ-н мэдээгээр найдвартай хангах



## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Манай компанийн ТУЗ-д гадаад, дотоодын нэр хүнд бүхий томоохон компаниудын удирдлагууд, хөрөнгө оруулагчид сонгогдон, нийт 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр 2017 онд амжилттай ажилласан.

### ЕРДИЙН ГИШҮҮД



**Бүрэнмэнд ЛХАГВАДОРЖ**  
Тэргүүн дэд захирал,  
БидиСЕК ҮЦК ХК

- Иргэний харъяалал Монгол
- Төрсөн он 1976
- Боловсрол: Дээд, Нефтийн инженер мэргэжилтэй
- ХЗЗ-д 15 жил ажилласан туршлагатай.



**Данзан ДАЯНБИЛГҮҮН**  
Гүйцэтгэх захирал,  
БидиСЕК ҮЦК ХК

- Иргэний харъяалал Монгол
- Төрсөн он 1976
- Боловсрол: Дээд Бизнесийн эдийн засагч мэргэжилтэй, МВА, санхүүгийн зах зээлд 16 жил ажилласан туршлагатай.



**ЖЕЙМС Пассин**  
Захирал, Портфель менежер Firebird Management ХХК

- Иргэний харъяалал АНУ Нью-Йорк хот
- Төрсөн он 1971
- Боловсрол: Эдийн засагч мэргэжилтэй
- ОУ-ын ХЗЗ-д ажилласан туршлагатай.



**Нарангэрэл БАТГЭРЭЛ**  
Дэд захирал,  
БидиСЕК ҮЦК ХК

- Иргэний харъяалал Монгол
- Төрсөн он, 1974
- Боловсрол, Олон улсын харилцааны дээд сургуулийг гадаад албаны ажилтан мэргэжлээр төгссөн.
- ХЗЗ-д 16 жил ажилласан туршлагатай



**Philip Khoury**  
Impera Capital ХХК,  
Istanbul - Захирал

- Иргэний харъяалал Их Британи
- Төрсөн он – 1969
- Боловсрол дээд

### ХАРААТ БУС ГИШҮҮД



**ХИТОШИ Тана**  
Ерөнхийлөгч EXE  
корпораци

- Иргэний харъяалал Япон
- Төрсөн он 1954
- Боловсрол: Дээд Эдийн засагч



**Дарамранз АМГАЛАНБАЯР**  
Захиргааны мэргэжилтэн  
MSM ХХК

- Иргэний харъяалал Монгол
- Төрсөн он 1975
- Боловсрол: Дээд Эдийн засагч мэргэжилтэй.
- ХЗЗ, уул уурхай, худалдааны салбарт ажилласан туршлагатай.



**Балжинням АМАРСАНАА**  
Захирал, ХЭРЭЭЖИ ХХК


- Иргэний харъяалал Монгол
- Төрсөн огноо 1977
- Олон улсын харилцаа гадаад албаны ажилтан мэргэжлээр төгссөн.
- Маркетингийн чиглэлээр ажилласан туршлагатай.




**Б. ЭНХБАЯР**  
Гүйцэтгэх захирал,  
Санаа EXE групп

- Иргэний харъяалал Монгол
- Төрсөн он 1980
- Боловсрол: Дээд Эдийн засагч хөрөнгийн зах зээл, санхүүгийн чиглэлээр ажилласан туршлагатай.


### Нийт Арилжаа



### Хувьцааны Арилжаа



### Бондын Арилжаа




### БРОКЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2017 онд МХБ дээр нийт 859.1 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн ба үүнээс 240.2 тэрбум төгрөгийн арилжаа буюу 27.9% -ийг “БидиСек ҮЦК” ХК хийж гүйцэтгэсэн байна.

2017 онд МХБ дээр нийт 76.4 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн ба үүнээс 12.7 тэрбум төгрөгийн арилжаа буюу 16.6% -ийг “БидиСек ҮЦК” ХК хийж гүйцэтгэсэн нь түрүү жилийнхтэй харьцуулахад 3.7 тэрбум төгрөгөөр их үзүүлэлттэй гарсан байна.

2017 онд МХБ дээр нийт 782.6 тэрбум төгрөгийн бондын арилжаа хийгдсэн ба үүнээс 227.5 тэрбум төгрөгийн арилжаа буюу 29% -ийг “БидиСек ҮЦК” ХК хийж гүйцэтгэсэн байна.

## ХАРИЛЦАГЧ



Тус компанийн харилцагчдийн тоо одоогийн байдлаар 200,000 давсан бөгөөд жил бүр тогтмол өсөн нэмэгдэж байна.

## АНДЕРРАЙТЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

**21 ТӨСӨЛ**



**APU COMPANY**  
Absolute. Pure. Unique.


2017 онд бид АПУ ХК-д Эвэргрийн Инвестмент ХХК-г нэгтгэх замаар өөрчлөн байнуулахтай холбогдуулан 338.12 тэрбум төгрөгийн дүн бүхий 321.3 сая ширхэг хувьцааг хаалттай хүрээнд нэмж гаргах төслийг амжилттай хэрэгжүүлсэн.



## САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### ХӨРӨНГӨ


Нийт Хөрөнгийн Хэмжээ /сая төгрөг/



Хөрөнгө Бүрэлдэхүүн /сая төгрөг/



Эргэлтийн хөрөнгө ба богино хугацаат хөрөнгө оруулалт /сая төгрөг/




Эргэлтийн бус хөрөнгө, түүний бүтэц /сая төгрөг/




## ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ

Хөрөнгийн эх үүсвэрийн бүрэлдэхүүн /сая төгрөг/




Эх үүсвэрийн бүтцэд өр төлбөр 40%, эзэмшигчийн өмч 60% байвал санхүүгийн хувьд эрсдэлгүй харьцаа гэж тооцдог бөгөөд манай компанийн хувьд 2017 оны байдлаар 13.5%, 86.5%-ийн харьцаатай байгаа нь хангалттай сайн үзүүлэлт юм.

## ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГ /тэрбум төгрөг/





## Орлогын задаргаа



- Брокерийн Үйл Ажиллагаа
- Андеррайтерийн Үйл Ажиллагаа
- ХОЗҮ-ний орлого
- Үнэт цаасны арилжааны цэвэр орлого
- Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн олз
- Компанийн бондын хүүгийн орлого
- Бусад

## САНХҮҮГИЙН ШИНЖИЛГЭЭ



Шинжилгээ	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он
Нэгж хувьцаанд ногдох ашиг (EPS)	135.6	26.6	(36.0)	188.74	(51.9)	80.2
Зах зээлийн үнэ ба бүртгэлийн үнийн харьцаа (ЗЗҮ/БҮ)	4.2	3.0	2.3	1.98	1.41	1.057
Үнэ ашгийн харьцаа (P/E)	26.6	91.7	n/a	10.27	n/a	15.1

**EPS** буюу нэгж хувьцаанд ногдох ашиг гэдэг нь компанийн нэгж хувьцааны цаана хэдэн төгрөгний ашиг олж байгааг харуулдаг.

**ЗЗҮ/БҮ** нь тухайн нэгж хувьцаанд ногдох бодит хөрөнгийн бүртгэлийн үнээс давуулж төлсөн үнэ буюу хөрөнгө оруулагчдын зүгээс компанийн ирээдүйд хэр итгэж байгааг харуулдаг чухал үзүүлэлт юм.

**P/E** буюу үнэ ашгийн харьцаа нь тухайн хувьцааны үнэ зах зээл дээр хэр бодитой үнэлэгдэж байгааг тодорхойлдог.



## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН



**ДАЛАЙВАН АУДИТ**  
Аудит, баталгаажуулалт, хөрөнгийн болон  
бизнесийн үнэлгээ, зөвлөх үйлчилгээ

Монгол Улс, Улаанбаатар хот-16066  
Баянгол дүүрэг, Амарсанаагийн гудамж-5  
Утас: 70005401, 70005404, 70005405  
Факс: +976-70005403  
Э.Шуудан: info@dalaiwanaudit.mn  
Вэб хуудас: www.dalaiwanaudit.mn

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

### “БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД

#### Хязгаарлалттай санал дүгнэлт

Бид 2017 оны 12 дугаар сарын 31-ээрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх нэгтгэсэн орлогын дэлгэрэнгүй тайлан, нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн “БиДиСек ҮЦК” ХК болон түүний охин компаниудын нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан асуудлын санхүүгийн тайланд үзүүлж болзошгүй нөлөөллийг эс тооцвол БиДиСек ҮЦК ХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн Монгол Улсын Сангийн яам, Санхүүгийн Зохицуулах Хорооноос батлан гаргасан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

#### Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл

Худалдааны болон бусад авлагын дүнд багтсан Дархан Хөвөн ХК-аас авах 484,982.4 мянган төгрөгийн авлага сүүлийн 6 жилийн хугацаанд төлөгдөөгүй, хөдөлгөөнгүй ба эргэн төлөгдөх эсэх нь тодорхойгүй, БиДиСек ҮЦК ХК нь тус авлагын эргэн төлөгдөх байдалд шинжилгээ хийж үнэ цэнийн бууралт орсон эсэхийг үнэлж тогтоогоогүй хэвээр байна.

Аудиторууд аудитын нэмэлт горим гүйцэтгэж тус авлагуудын бодит үнэ цэнийг хэмжиж залруулга хийх боломжгүй байсан.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудиторын хязгаарлалттай дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой гэж үзэж байна.

#### Аудитын гол асуудлууд

Аудитын гол асуудлууд нь бидний мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайланд хийсэн бидний аудитад хамгийн их анхаарал татсан асуудал байдаг. Харин бидний гаргасан тайланд материаллаг хэмжээний аудитын гол асуудал байхгүй хэмээн тодорхойлж байна.

#### Бусад мэдээлэл

Компани нь аудитласан нэгтгэсэн санхүүгийн тайланг хүлээн авч хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлсний дараа жилийн үйл ажиллагааны тайланг бэлтгэдэг. Аудитлагдсан нэгтгэсэн тайланг хүлээн авсны дараа жилийн тайлангаа хүргүүлэх талаар удирдлага мэдэгдсэн тул аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй.

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

### Санхүүгийн тайлангийн талаар удирдлага болон засаглах удирдлагын хүлээх хариуцлага

Удирдлага нь СТОУС-уудын дагуу нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хүлээхээс гадна залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд зайлшгүй чухал гэж тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага компанийн үйл ажиллагааг төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагаагаа зогсоох, ингэхээс өөр сонголтгүй байхаас бусад тохиолдолд удирдлага нэгтгэсэн санхүүгийн тайлангаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх хариуцлагыг хүлээх ба тасралтгүй байдалтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлд ашигласан тасралтгүй байдлын суурийг хэрэглэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Компанийн засаглах удирдлага нь нэгтгэсэн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

### Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага

Бидний зорилго бол нэгтгэсэн санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгөхгүй юм.

Залилан эсвэл алдаанаас шалтгаалан буруу тайлагнал үүсч болох ба дангаараа эсвэл нийтдээ материаллаг гэж үзсэн бол санхүүгийн тайланд тулгуурлан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх боломжтой юм.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан мэргэжлийн шийдэл гаргаж ажилласан. Мөн бид дараах ажлуудыг хийсэн:

- Нэгтгэсэн санхүүгийн тайланд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагнал байх эрсдэлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлүүдэд хариу аудитын горимуудыг тодорхойлж хэрэгжүүлсэн, мөн дүгнэлтийн үндэслэл болох аудитын хангалттай нотолгоог олж авсан. Зөвхөн нэг алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, дотоод хяналтыг үл хэрэгсэх эсвэл гуйвуулах зэрэг залилангаас шалтгаалсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлтэй.
- Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд компанийн дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгогүй.
- Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.
- Хэрэв компанийн тасралтгүй байх чадавхид материаллаг тодорхойгүй байдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт анхаарлаа хандуулах болно. Хэрэв энэ талаар холбогдох тодруулгад хангалттай дурьдаагүй байвал бид аудитын дүгнэлтээ өөрчлөх болно. Бидний өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайланг огноолох өдөр хүртэлх аудитын нотолгоонд суурилна. Иймд компанийн тасралтгүй байх чадварт нөлөөлөх нөхцөл байдал ирээдүйд үүсч болох юм.
- Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, толилуулга болон тодруулгыг бид бүхэлд нь шалгаж санхүүгийн тайлан нь ажил гүйлгээ ба үйл явдлыг үнэн зөв харуулсан эсэхийг үнэлсэн.

"DALAIWAN AUDIT" Co.,Ltd  
CERTIFIED ACCOUNTING, AUDITING  
& APPRAISAL

**ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН**  
(үргэлжлэл)

- Нэгтгэсэн санхүүгийн тайлантай холбоотой дүгнэлт гаргахын тулд бид компаниудад хамаарах аж ахуйн нэгж болон бизнесийн үйл ажиллагааны санхүүгийн мэдээлэлтэй холбоотой хангалттай хэмжээний тохиромжтой аудитын баримт нотолгоо олж авсан.

Бид засаглах удирдлагатай аудитын цар хүрээ, хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар харилцсан.

Мөн бид засаглах удирдлагад аудиторын хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудыг мэдэгдсэн бөгөөд бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц аливаа харилцаа холбоо, түүнээс сэргийлэх арга хэмжээнүүд болон бусад асуудлуудын талаар ярилцсан.

Засаглах удирдлагатай харилцсаны үндсэн дээр бид тайлант хугацааны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар хамгийн чухал гэж авч үзсэн асуудлуудыг тодорхойлж аудитын гол асуудлууд гэж үзсэн. Бид олон нийтэд мэдээллэх нь сөрөг үр дагаврыг авчрах учраас хууль тогтоомжоор хориглосон байдаг асуудлаас бусад аудитын асуудлуудыг аудиторын тайландаа харуулсан.

**Тайлангийн хэрэглээ**

Энэхүү тайланг Компанийн тухай хуулийн 94-р зүйлд заасны дагуу “БиДиСек ҮЦК” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хэрэгцээнд зориулан бэлтгэсэн бөгөөд бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа гуравдагч этгээдийн өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.



2018 ОНЫ 03 ДУГААР  
САРЫН 19-НИЙ ӨДӨР

“БИ ДИ СЕК ҮЦК” ХК-ийн 2017 оны 12-р сарын 31-нээр тасалбар болгосон  
 НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

2017 оны 12 дугаар сарын 31

/Мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Тодруулга	2017.12.31	2016.12.31
<b>ХӨРӨНГӨ</b>			
<b>Эргэлтийн хөрөнгө</b>			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	5.1	2,015,230.3	166,312.2
Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдсэн санхүүгийн хөрөнгө	5.2	9,287,794.8	6,384,626.4
Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө	5.7	778,166.2	1,046,616.5
Худалдааны ба бусад авлага	5.3	1,406,739.3	1,500,065.5
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө	5.4		70,780.5
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>		<b>13,487,930.6</b>	<b>9,168,401.1</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>			
Өмч, барилга, тоног төхөөрөмж - цэвэр	5.5	5,291,082.5	5,447,126.6
Биет бус хөрөнгө - цэвэр	5.6	17,825.8	5,395.2
Өмчөөр тайлагнагдах хараат компанид оруулсан хөрөнгө оруулалт	5.7	1,000.0	1,000.0
Урт хугацаат авлага	5.8	98,259.7	102,491.7
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>		<b>5,408,168.0</b>	<b>5,556,013.5</b>
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>		<b>18,896,098.6</b>	<b>14,724,414.6</b>
<b>ӨР ТӨЛБӨР</b>			
<b>Богино хугацаат өр төлбөр</b>			
Худалдааны ба бусад өглөг	5.9	2,229,198.1	118,395.3
Банкны богино хугацаат зээл	5.10	668,308.1	-
Орлогын албан татварын өглөг	5.11	73,235.6	793.6
Бусад татвар, шимтгэлийн өглөг	5.11	74,371.9	19,011.4
Хүүний өглөг	5.10	6,417.2	-
Урьдчилж орсон орлого	5.12	160,000.0	-
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>		<b>3,211,530.9</b>	<b>138,200.3</b>
<b>Урт хугацаат өр төлбөр</b>			
Хойшлогдсон татварын өглөг			
Банкны зээл урт хугацаат			
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>		<b>-</b>	<b>-</b>
<b>Нийт өр төлбөр</b>		<b>3,211,530.9</b>	<b>138,200.3</b>
<b>ӨМЧ</b>			
Хувьцаат капитал	5.13	9,326,797.6	9,326,797.6
Дахин үнэлгээний нэмэгдэл	5.13	3,824,524.4	3,824,524.4
Хуримтлагдсан ашиг	5.13	2,533,245.7	1,434,892.3
<b>Нийт өмч</b>		<b>15,684,567.7</b>	<b>14,586,214.3</b>
<b>НИЙТ ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР</b>		<b>18,896,098.6</b>	<b>14,724,414.6</b>

"DALAIWAN AUDIT" Co., Ltd  
 CERTIFIED ACCOUNTING, AUDITING  
 & APPRAISAL



"БИ ДИ СЕК ҮЦК" ХК-ийн 2017 оны 12-р сарын 31-нээр тасалбар болгосон  
 НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**НЭГТГЭСЭН АШИГ, АЛДАГДАЛ БОЛОН БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН**

2017 оны 12 дугаар сарын 31

/Мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Тодруулга	2017.12.31	2016.12.31
Үндсэн үйл ажиллагааны орлого	5.14	2,106,342.7	879,635.7
Бусад үйл ажиллагааны орлого	5.15	136,400.6	121,215.0
Үйл ажиллагааны зардал	5.16	(1,769,352.4)	(1,501,327.4)
<b>Үйл ажиллагааны ашиг/алдагдал</b>		<b>473,390.9</b>	<b>(500,476.7)</b>
Санхүүгийн орлого	5.17	758,591.5	529,962.9
Санхүүгийн зардал	5.17	(177,927.5)	(756,949.5)
Өмчөөр тайлагнагдах хараат компанийн цэвэр ашгийн ногдох хувь	5.18	141,898.8	107,930.5
Үйл ажиллагааны бус орлого/(зардал)	5.19	(17,445.3)	(85,915.9)
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг/(алдагдал)</b>		<b>1,178,508.4</b>	<b>(705,448.7)</b>
Орлогын татварын зардал	5.20	(80,154.8)	(5,065.6)
<b>Тайлант жилийн цэвэр ашиг/(алдагдал)</b>		<b>1,098,353.6</b>	<b>(710,514.3)</b>
<b>Бусад дэлгэрэнгүй орлого:</b>			
<b>Ашиг, алдагдлаар дахин ангилагдахгүй зүйлс:</b>			
Дахин үнэлгээний нэмэгдэл		-	-
<b>Ашиг, алдагдлаар дахин ангилагдах зүйлс:</b>			
Богино хугацаат хөрөнгө оруулалтын хэрэгжээгүй олз/(гарз)		-	-
Хэрэгжээгүй олзод ногдох хойшлогдсон татвар		-	-
<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>		<b>-</b>	<b>-</b>
<b>Нийт дэлгэрэнгүй орлого/(зардал)</b>		<b>1,098,353.6</b>	<b>(710,514.3)</b>
<b>Нэгж хувьцаанд ногдох ашиг/(алдагдал)</b>			
Суурь (төгрөг)	5.21	80.2	(51.9)

"DALAIWAN AUDIT" Co., Ltd  
 CERTIFIED ACCOUNTING, AUDITING  
 & APPRAISAL

"БИ ДИ СЕК УЦК" ХК-ийн 2017 оны 12-р сарын 31-нээр тасалбар болгосон  
НЭГТГЭСЭН САХУУГИЙН ТАЙЛАН

**НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛГИЙН ТАЙЛАН**

2017 оны 12 дугаар сарын 31

Үзүүлэлт	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Дахин үнэлгээний ноёд	Үнэт цаасны БҮЦ-ийн хэрэгжээгүй олз/(гарз)	/Мянган төгрөгөөр/	
					Хуримтлагдс ан ашиг	Нийт өмч
<b>2015 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>1,347,753.6</b>	<b>7,473,668.9</b>	<b>3,824,524.4</b>	<b>-</b>	<b>2,629,046.8</b>	<b>15,274,993.7</b>
Гаргасан хувьцаа	21,734.7					21,734.7
Нэмж төлөгдсөн капитал		483,640.4				483,640.4
Дахин үнэлгээний нэмэгдэл						
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз/(гарз)					(710,514.3)	(710,514.3)
Хуваарилсан ногдол ашиг					(483,640.4)	(483,640.4)
Тайлант жилийн цэвэр ашиг						
Залруулга						
<b>2016 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>1,369,488.3</b>	<b>7,957,309.3</b>	<b>3,824,524.4</b>	<b>-</b>	<b>1,434,892.1</b>	<b>14,586,214.1</b>
Гаргасан хувьцаа						
Нэмж төлөгдсөн капитал						
Дахин үнэлгээний нэмэгдэл						
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз/(гарз)						
Хуваарилсан ногдол ашиг						
Тайлант жилийн цэвэр ашиг					1,098,353.6	1,098,353.6
Залруулга						
<b>2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>1,369,488.3</b>	<b>7,957,309.3</b>	<b>3,824,524.4</b>	<b>-</b>	<b>2,533,245.7</b>	<b>15,684,567.7</b>

"DALAIVAN AUDIT" Co., Ltd  
CERTIFIED ACCOUNTING, AUDITING  
& APPRAISAL

"БИ ДИ СЕК ҮЦК" ХК-ийн 2017 оны 12-р сарын 31-нээр тасалбар болгосон  
НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2017 оны 12 дугаар сарын 31

/Мянган төгрөгөөр/

<u>Үзүүлэлт</u>	<b>2017.12.31</b>	<b>2016.12.31</b>
<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<i>Мөнгөн орлогын дүн</i>	<i>11,602,772.8</i>	<i>1,562,013.7</i>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,242,501.2	1,148,032.2
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
Бусад орлого	9,360,271.6	413,981.5
<i>Мөнгөн зарлагын дүн</i>	<i>8,589,255.6</i>	<i>1,146,509.5</i>
Ажиллагсад төлсөн мөнгө	443,898.8	636,925.4
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	81,852.0	117,681.6
Түүхий эд, материал худалдан авахад төлсөн	29,550.1	12,238.1
Ашиглалтын зардалд төлсөн	48,196.7	123,776.9
Түлш шатахуун, сэлбэг хэрэгсэлд төлсөн	38,664.9	27,399.7
Хүүний төлбөрт төлсөн	14,433.1	27,859.1
Татварын байгууллагад төлсөн	55,770.7	22,294.3
Шимтгэл хураамжид төлсөн	54,465.0	36,805.0
Даатгалын төлбөрт төлсөн	-	2,224.8
Бусад мөнгөн зарлага	7,822,424.3	139,304.6
<i>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</i>	<i>3,013,517.2</i>	<i>415,504.2</i>
<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<i>Мөнгөн орлогын дүн</i>	<i>2,516,832.9</i>	<i>493,178.4</i>
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	65,740.0
Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	2,247,592.9	427,438.4
Олгосон зээлийн эргэн төлөлт	269,240.0	-
<i>Мөнгөн зарлагын дүн</i>	<i>4,286,378.8</i>	<i>552,971.9</i>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	17,525.3	3,410.0
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	4,268,853.5	549,561.9
<i>Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ</i>	<i>(1,769,545.9)</i>	<i>(59,793.5)</i>
<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<i>Мөнгөн орлогын дүн</i>	<i>3,101,160.5</i>	<i>84,963.5</i>
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	3,061,394.3	39,507.2
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
Бусад мөнгөн орлого	39,766.2	45,456.3
<i>Мөнгөн зарлагын дүн</i>	<i>2,486,558.5</i>	<i>348,320.0</i>
Зээл авсан, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	2,486,558.5	348,320.0
Төлсөн ногдол ашиг	-	-
<i>Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээ</i>	<i>614,602.0</i>	<i>(263,356.5)</i>
<b>Валютын ханшийн зөрүү</b>	<b>(9,655.3)</b>	<b>7,530.4</b>
<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>1,848,918.0</b>	<b>99,884.6</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	166,312.2	66,427.6
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	"D" 2,015,230.3 IT Co., Ltd 166,312.2	

CERTIFIED ACCOUNTING, AUDITING  
& APPRAISAL

## ТАЙЛАНГИЙН ГУРАВДАХЬ ХЭСЭГ

Компани нь 2017 оны 4 сарын 26-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлыг шийдвэрлэсэн.

- a. Компанийн 2016 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажсан дүгнэлтийг тайлагнах
- b. Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт
- c. Компани ногдол ашиг тараах эсэх талаарх ТУЗ-н гаргасан шийдвэрийг танилцуулах
- d. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
- e. ТУЗ-ийн 2017 оны төсөв батлах
- f. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай
- g. Компанийн зарласан болон гаргасан хувьцааны тоог тогтоох тухай

Компани нь 2016 оны 4 сарын 25-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлыг шийдвэрлэсэн.

- a. Компанийн 2015 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажсан дүгнэлтийг тайлагнах
- b. Компанийн 2015 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг батлах
- c. Компани ногдол ашиг тараах эсэх тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг хэлэлцэж батлах
- d. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
- e. ТУЗ-ийн 2016 оны төсөв батлах

Компани нь 2015 оны 3 сарын 26-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлыг шийдвэрлэсэн.

- a. Компанийн 2014 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажсан дүгнэлтийг тайлагнах
- b. Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийгдсэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлтийг батлах
- c. Компани нь ногдол ашиг тараах эсэх талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэж батлах
- d. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
- e. ТУЗ-ийн 2015 оны төсөв батлах
- f. Компанийн нэрэнд өөрчлөлт оруулах тухай
- g. Нэмэлт хувьцааны арилжааны тайланг тайланг хэлэлцэх
- h. Шинээр татан төвлөрүүлсэн хөрөнгөтэй холбоотойгоор бизнес төлөвлөгөө, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тодотголыг танилцуулах
- i. Үнэт цаасны танилцуулгын өөрчлөлтийг хувьцаа эзэмшигчдэд танилцуулах
- j. Компанийн зарласан болон гаргасан хувьцааны тоог тогтоох тухай
- k. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай



